



ТАВАНТОЛГОЙ ХК

ӨМНӨГОВЬ АЙМАГ

“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИ

Өмнөговь, Цогтцэций сум, Утас: 7535-5555, 9500-1619

и-мэйл: info@tavantolgoi.mn

2024.04.30 № 1-417

танай _____-ны № _____-т

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

“Говьтүрүү” ХХК-иас ирүүлсэн 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн ГТ24/54 тоот албан бичигтэй танилцаад дараах хариуг хүргүүлж байна.

Манай компаниас 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр зарласан “Хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажил /багцтай/” ТТХК/20240101011 дугаар бүхий тендерийн баримт бичгээс доорх асуултад тодруулга хүссэн байна.

7. “Банкнаас лизинг, зээлээр аваад ашиглаж байгаа техникүүдэд зээлийн гэрээг хавсаргахгүйгээр зөвхөн тухайн банкны тодорхойлолтоор баталгаажуулж болох уу” гэсэн дээр тодруулга өгөхөд тус техникүүд нь өөрийн эзэмшлийнх байх бөгөөд зээлийн гэрээг хавсаргах мөн холбогдох нотлох баримтуудыг ирүүлэх шаардлагатай болно.
8. “CAT390 экскаватор нь Барловорлд монголиа ХХК-аас 6м3 шанаганы багтаамжтай худалдан авсан ба авто үйлчилгээний нэгдсэн сан /autobox.mn/ сайт дээр гаалийн мэдээлэл хэсэгт шанаггүй гэж тэмдэглэсэн байна энэ тохиолдолд яах вэ?” гэсэн дээр тодруулга өгөхөд тендерийн баримт бичгийн ТШЗ 19.1-д “Дээрх машин механизмын талаарх мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-ээр дамжуулан Авто тээврийн үндэсний төвийн мэдээллийн сангаас лавлана. Санал болгож буй машин механизмын мэдээлэл үнэн зөв, бодит байдлаас зөрүүтэй бүртгэгдсэн аливаа асуудал нь захиалагч хариуцлага хүлээхгүй бөгөөд төрийн анхдагч өгөгдөл хадгалж буй мэдээллийн сангийн мэдээлэлд үндэслэн үнэлгээг хийх болохыг анхаарна уу!!!” гэж заасны дагуу шийдвэрлэнэ. Иймээс зөрүүтэй бүртгэгдсэн талаарх мэдээллийн нотлох баримтаа ирүүлэх нь оролцогчдод нээлттэй болно.
9. “tender.gov.mn сайтад техникийн чадавхийг бүртгэхдээ даац хэсэгт механизмыг тухайн техникийн үзүүлэлтээр нь /ковш шанаганы хэмжээ, автогрейдер хутганы урт гэх мэт/ бүртгэж болох уу?” гэсэн дээр тодруулга өгөхөд ТШЗ 19.1-д “Тоног төхөөрөмж, машин механизмын мэдээллийг худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-ээр дамжуулан илгээх зааварчилгааг хэрэглэгчийн хөтөч хэсэгт орж танилцана уу” гэж зааснаар ирүүлэхийг зөвлөж байна.
10. “Тухайн техникийн үйлдвэрийн каталоги болон авто үйлчилгээний нэгдсэн сан /autobox.mn/ сайт дээрх мэдээлэл зөрүүтэй харагдаж байгааг аль

тодорхойлолтоор нь шаардлага хангасан гэж үзэх вэ?” гэсэн дээр тодруулга өгөхөд тендерийн баримт бичгийн ТШЗ 19.1-д “төрийн анхдагч өгөгдөл хадгалж буй мэдээллийн сангийн мэдээлэлд үндэслэн үнэлгээг хийх болохыг анхаарна уу!” гэж зааснаар шаардлага хангасан эсэхийг тогтоох болно.

11. “Үнийн тохируулга хэсэгт Дизель түлшний үнийн өсөлт, бууралт нь нэмэх, хасах 20 хувь үед үнийн тохируулга хийнэ болон Ашигт малтмал, газрын тосны газрын хил үнэ 10 хувиас илүү өсөх, эсхүл буурахаар бол үнийг тохируулна гэж заасан байна. Уг хоёр заалтын алыг нь баримтлах талаар тодруулга өгнө үү.” гэсэн дээр тодруулга өгөхөд тендерийн баримт бичгийн ТШЗ 21.6-д “Тендер зарласан өдрийн Ашигт малтмал, газрын тосны газраас зарласан Дизель түлшний үнийн өсөлт, бууралт нь нэмэх, хасах 20 хувь үед үнийн тохируулга хийнэ. Мөн Ашигт малтмал, газрын тосны газрын хил үнэ 10 хувиас илүү өсөх, эсхүл буурахаар бол үнийг тохируулна.” гэж заасны аль нэг нөгцөл байдал үүссэнээс шалтгаалж хэрэглэхийг ойлгож болно.
12. “Тосолгооны машин, Хог хаягдал тээвэрлэх машин, Автокран, Дугуй өргөгч, Түлшний машин, Галын машин, Түргэн тусламжийн машин, Гэрэлтүүлэгч цамхаг, Усны насос зэрэг бусад туслах техникүүдийн үйлдвэрлэгчийн брошурыг тендерийн материалд хавсаргах шаардлагатай эсэхийг тодруулж өгнө үү.” гэсэн дээр тодруулга өгөхөд тендерийн баримт бичгийн ТШЗ 19.1-д “Үйлдвэрлэгчээс гаргасан техникийн үзүүлэлт бүхий каталоги танилцуулга ирүүлнэ.” гэж зааснаар хавсаргаж ирүүлэх шаардлагатай болно.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Ч.ГҮНЖДАГВА

